

8. 1935 оны 7-р сарын 27-нд Цахар мужийн захирагч Цин, Японы генерал Доихара нар Цахараас Хятадын цэргийг гаргах хэлэлцээр байгуулжээ.
9. Mongolia in Soviet-Japanese Relations, 1933-1936, by Bridges Brian. p. 27, Nish ed. London, 1982.
10. ДВП т. 18, с. 463.
11. МАХН-ын түүхэнд холбогдох баримт бичгүүд I дүгээр дэвтэр. 1966, 312 дахь тал
12. НТА, ф. 4, т. 5, х.н, 187, 81.83 дахь тал
13. ДВП. т. 19 с 275.
14. ДВП, т. 19, с. 197.
15. ДВП т. 19, с. 37.
16. ДВ. т. 19, с. 197.
17. Монгол Зөвлөлтийн харилцаа, I боть, 1976, 399 дэх тал
18. ДВП, т.19, с. 543.
- 19 ДВП, т. 20, с. 701.
20. «Год кризиса». — Документы и материалы. 1938—1939, т. 1, с. 263.
21. «Год кризиса». -Документы и материолы. 1938—1939, т. 1 с. 476.

ШИНЭ БОДЛОГО, ШИНЭ АРГА*

Г. Төмөрчулуун*

Өмнөх өгүүлэлд бид БНМАУ-ын гадаад хүрээлэлтэй холбогдсон бодлогын чанартай асуудалд голлон анхаарсан билээ. Гадаад бодлогод гадаад орчин, дэлхийн улс орнуудын бодлого, үйл ажиллагаа шийдвэрлэх үүрэгтэй боловч гадаад бодлогын тодорхой асуудлаар шийдвэр гаргах үйл явц түүнээс дутахааргүй чухал байдаг.

Манай олон улсын судлал өнөөг хүртэл гадаад бодлого судлалын зөвхөн гадаад талыг судалж ирсэн бөгөөд гадаад бодлогын нэг чухал бүрэлдэхүүн хэсэг болох шийдвэр гаргах үйл явцын судалгаа шинжилгээг орхигдуулж иржээ. Ийм байдал нэг талаар гадаад бодлогын шийдвэр гаргах үйл явцын тухай шинжлэх ухааны салбар харьцангуй сүүлд хөгжсөнтэй холбоотой боловч¹, нөгөө талаар О. Латтимор агсны улс төр судлалын нэр томъёоны эргэлтэнд анх оруулсан «дагуул»² (зарим эрдэмтдийн «Төв», «хязгаар» улсын онолоор бол «хязгаар» улс)³ улсын тухай онолыг хэрэгжүүлж ирсэнтэй холбоотой юм.

Бие даасан гадаад бодлого явуулна гэдэг нь гадаад бодлогын гадаад, дотоод талыг цогцолбороор судлахыг шаардаж байна. Энэ асуудлаар «Өрнө, Дорно» сэтгүүлээр дамжуулан өргөн хэлэлцүүлэг явуулах нь Монгол улсын гадаад бодлогын шинжлэх ухааны үндэслэлийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтойг бодож, эргэцүүлэл төдий хэдэн санаа бичив. Сэтгүүлийн зайнаас шалтгаалан энд улс орны газарзүйн байрлал, хүн ам, цаг уур, шашны уламжлал, эдийн засгийн хөгжлийн төвшин зэрэг дотоодын чанартай олон зүйл гадаад бодлогын шийдвэр гаргахад хэрхэн нөлөөлдгийг авч үзээгүй болно:

Профессор Ханс Моргентау дипломат бодлогын дөрвөн зорилтыг дараах байдлаар тодорхойлсон нь буй. Үүнд:

1. «Дипломат бодлого хүч чадавхи, бололцоондоо тохируулан өөрийн зорилтыг тодорхойлох ёстой.
2. Дипломат бодлого нөгөө улсынхаа зорилтыг тодорхойлох ёстой.

* Төгсгөл. Эхний хэсэг нь 1992. № 1-д

* Дэд эрдэмтэн.

3. Дипломат бодлого хоёр улсын зорилт хоорондоо хэр авцалдаж байгааг тодруулах ёстой.

4. Дипломат бодлого дээрхэд тулгуурлан өөрийн зорилтыг хэрэгжүүлэх аргыг зөв сонгох ёстой»⁴.

Гадаад бодлогын шийдвэр гаргах үйл явц энд дурдсан дөрвөн зорилтыг хэрэгжүүлэхтэй шууд холбоотой. Шийдвэр гаргах үйл явц зохион байгуулалтын, оюуны гэсэн хоёр үндсэн хэсгээс бүрдэж байна.

Гадаад бодлогын шийдвэр гаргах дээд удирдлага улс орнуудад олон янз. Жишээ нь, гадаад бодлогын гол шийдвэрийг АНУ, ХОУ-д, ерөнхийлөгч, Япон, Англид ерөнхий сайд, ХБНГУ-д канцлер, Хятадад ХКН гаргаж байдаг.

Монгол улсын шинэ үндсэн хуулийн дагуу тус улсын гадаад бодлогын асуудлуудаар шийдвэр гаргахад Улсын Их Хурал, ерөнхийлөгч, Засгийн газар гурвуулаа оролцож байх аж. Чингэхдээ гадаад бодлогын ерөнхий чиг шугамыг Улсын Их Хурал тодорхойлж, Засгийн газар хэрэгжүүлж байхаар тогтоосон байна. Үүний зэрэгцээ гадаад бодлогын зарим тодорхой асуудлыг ерөнхийлөгчийн бүрэн эрхэд хамааруулсан буй. Ерөнхийлөгчийн тэргүүлэх Үндэсний аюулгүй байдлын зөвлөл гадаад бодлогод чухал үүрэгтэй байх нь мэдээж. Ийм тогтолцоо манайд шинээр бүрэлдэж байгаа тул гадаад бодлогын чухам ямар практик асуудлыг хэн нь шийдэж байх вэ гэдгийг одоо хэлэхэд хэцүү юм. Ажлын тодорхой хуваарь байх болов уу гэж бодогдоно. Гэвч энэ бол жичдээ сэдэв билээ.

Гадаад бодлогын шийдвэр гаргахад юуг анхаарах, ямар хүчин зүйлүүдийг бодолцох ёстой вэ? Өөрөөр хэлбэл, энд гадаад бодлогын дотоод тал буюу түүний «гал зуухны» тухай асуудлыг хөндөхийг эрмэлзэв.

Шийдвэр гаргах үйл явцын нэг хэсэг болох оюуны үйл ажиллагааг мэдээлэл, мэдээллийг дамжуулах, дүн шинжилгээ хийх, шийдвэр гаргах гэсэн дөрвөн хэсэгт хувааж болох мэт.

Мэдээлэл

Гадаад бодлогын талх нь мэдээлэл мөн. Ямар ч гадаад бодлого бодтой, үнэн зөв мэдээлэлгүйгээр амжилтад хүрч байсан нь ховор Буруу мэдээллээс улсын эрх ашиг хохирох нь олонтаа. Орчин үеийн олон улсын харилцааны түүх ийм жишээгээр дүүрэн байдаг. 1979 онд Иранд лалын хувьсгал гарахаас өмнө АНУ Ираны Шагийг дэмжиж байв. Улс оронд Шагийн байр суурь нөлөөтэй хэвээр эсэх талаар төрийн департаментын даалгаварт тэр үед Тегеранд сууж байсан элчин сайд нь хариу болгон мэдээлэхдээ «Иранд хувьсгал бүү хэл, хувьсгалын үнэр ч алга»⁵ гэсэн хариу өгчээ. Гэвч хувьсгалт гардгаараа тараад Иран дахь АНУ-ын байр суурь, нөлөөнд ноцтой цохилт болж урьд холбоотой байсан хоёр улс дайсан болсон билээ. 1941 онд япончууд Пирл Харборыг бөмбөгдөх үед АНУ-ын Токио дахь элчин генерал Мак Артур мэдээгүй унтаж байсан гэдэг.

Мэдээллийн эх сурвалж олон янз. Үүнд гадаадын хэвлэлийн агентлагууд, тусгай албад, гадаадад суугаа дипломат төлөөлөгчийн газруудын (ДТГ) болон бусад мэдээлэл хамаарна. Гэвч чанар нь харилцан адилгүй. Цөөн ДТГ-тай жижиг улс мэдээллээр гол төлөв хомс байдаг. Британийн хамтын нийгэмлэг өдий болтол оршин тогтносоор ирсний нэг шалтгаан нь түүний гишүүн орнууд (гол төлөв бага жижиг улсууд) Мэдээлэл олж авах гэсэн нийтлэг зорилттой холбоотой. НҮБ, ЭУНХ зэрэг олон улсыг хамарсан байгууллага, хөдөлгөөн бага жижиг улсуудын хувьд мэдээллийн чухал эх сурвалж болж, мэдээллийн хомсдлыг ямар нэг хэмжээгээр багасгаж байдаг. Өөрөөр хэлбэл, олон

улсын харилцаанд өргөн оролцох тусам мэдээлэл баяжиж байдаг байна.

Мэдээллийн чанарт нөлөөлөгч дараагийн чухал хүчин зүйл бол дипломатуудын хувийн чанар, мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадвар, соёлын төвшин зэрэг юм. 1937 онд Германд Английн элчин сайдаар томилогдсон Невиль Хиндерсон ихэнх цагаа ан хийж, загасчилж өнгөрөөн төвдөө бараг мэдээ өгдөггүй байсан нь тэр үеийн Англи Германы харилцаанд нөлөөлсөн гэдэг.

Цаашилбал мэдээллийн чанар хоёр орны харилцааны байдлаас ихээхэн хамаарна. Ойр дотно, нягт харилцаатай хоёр орны хоорондын мэдээлэл гол төлөв өргөн, бодьтой, итгэмжилсэн шинжтэй байдаг. Харилцаа муу хоёр орон бие биеийнхээ тухай мэдээллээр хомс тул гол төлөв тухайн оронтой сайн харилцаатай гурав дахь орны төлөөлөгчдөөс мэдээлэл олдог жишээтэй юм.

Мэдээллийн чанар техникийн дэвшлээс ихээхэн хамаарна. Сансрын холбоо, халуун шугам, факс зэрэг орчин үеийн холбоогүйгээр гадаад бодлогыг амжилттай явуулах аргагүй. Болсон үйл явдлын тухай мэдээлэл хэдийчинээ түргэн байвал шийдвэр гаргагчдад төдийчинээ ашигтай.

Мэдээллийг дамжуулах

Шийдвэр гаргах үйл явцын дараагийн шат нь мэдээг шийдвэр гаргагчдад хүргэж дамжуулах явдал юм. Тодорхой мэдээг дамжуулна гэдэг бол тун нарийн асуудал. Мэдээг жинхэнэ утгаар нь дамжуулна гэж бараг байдаггүй. Буруу зөрүү ойлголцох нь элбэг. Жишээ нь, «цас» гэдэг үгийг монгол хүн нэг янзаар ойлгож байхад бенгали хүн тэс өөрөөр хүлээж авна. Нэг хэлээр ярьдаг хоёр хүн бие биеийгээ бүрэн төгс ойлгоно гэж бараг байхгүй. Учир нь хүмүүс ав адилхан боловсрол, зан араншин, соёл, сэтгэлгээтэй байна гэж үгүй. Ялангуяа ондоо соёл, хүмүүжилтэй хүмүүсийн хооронд ийм явдал элбэг тохиолддог.

Мэдээлэл дамжуулахад тохиолддог өөр нэг зовлон бол тухайн мэдээлэл шийдвэр гаргагчийн өөрийн бодол хүсэл, итгэл үнэмшилд нийцэхгүй байх явдал юм. Ийм тохиолдолд тухайн мэдээг шийдвэр гаргагч хэрэгсэхгүй өнгөрөөдөг. Гитлер ЗХУ-д довтлох гэж байгааг Москва дахь Английн элчин сайд С. Криппс Сталинд мэдэгдэхэд тэр үед Гитлертэй үл довтлох тухай нууц гэрээ байгуулчихаад байсан Сталин тэр мэдээг үндэсгүй хэмээн хэрэгсэхгүй өнгөрөөсөн гэдэг⁶. Үүний нэгэн адилаар Гитлерийн төлөвлөгөөний тухай Зөвлөлтийн тагнуулчдын мэдээг ч тэр ойшоон үзээгүй өнгөрөөжээ.

Хүмүүс зан араншин, соёл боловсрол, сонирхол, мэргэжлийн төвшнөөр адилгүй тул мэдээллийг өөр өөрөөр тусгаж, өөр өөрсдийн ойлголтоор бусдад (шийдвэр гаргагчдад дамжуулдаг.

Лорд Солсберийн хэлсэнчлэн эмч хүний нүдэнд бүх хүн өвчтэй болж харагддаг, цэрэг хүний нүдэнд бүх хүн аюултай болж харагддаг, лам хуврагын нүдэнд бүх хүн бохирдсон болж харагддаг. Иймд шийдвэр гаргагчид нэг мэдээг өөр өөрсдийнхээ ойлгосноор тайлбарлах нь элбэг. Иймэрхүү явдал нэг яамны хэд хэдэн хэлтэст ч тохиолдож л байдаг. Ийм бие биентэйгээ зөрчилдсэн, заримдаа үгүйсгэсэн олон мэдээнд дүн шинжилгээ хийж нэгтгэх нь зайлшгүй.

Дүн шинжилгээ хийх

Шийдвэр гаргах үйл явцын хамгийн хариуцлагатай шат нь цуглуулсан мэдээндээ дүн шинжилгээ хийхэд оршино. Улс орны гадаад, дотоод байдал, уг асуудлын мөн чанар, боломжийн үр дагавар, эерэг сөрөг нөлөө зэрэг олон хүчин зүйлийг харгалзаж үзэх нь мэдээж.

Гэвч хамгийн чухал нь дипломатын мэргэжлийн өндөр төвшинд тэр их мэдээллээс хэрэгтэйг нь авч задлан шинжлэх, ямар ч ноцтой хямралын үед барьц алдалгүй, уужуу тайван сэтгэх, цаг хугацааны хүчин зүйлийг нарийн бодолцох явдал юм.

Гадаад бодлогын хурц асуудалд дүн шинжилгээ хийхдээ тухайн үйл явдалд өөрийн байр сууринаас бус нөгөө улсын байр сууринаас хандаж байх нь онцгой чухал. Энэ нь өөрийн улсын эрх ашгийг огоорно гэсэн хэрэг бус харин өөрийн болон цаадах улсын байр суурийг хамтад нь харж дүгнэнэ гэсэн хэрэг юм. Ухаандаа А, Б гэсэн хоёр улс байлаа гэхэд Б улсын шийдвэр гаргагчид А улсын оронд байсан бол ямар дүгнэлт хийх, ямар шийдвэр гаргах байсан бэ гэдгийг төсөөлж олохыг энд хэлж байна.

Цаашилбал дүн шинжилгээг хэд хэдэн хувилбараар хийж, өөрийн оронд хувилбар тус бүрийн үзүүлж болох боломжийн эерэг, сөрөг нөлөөлөл, үр дагаврыг тогтоох нь чухал.

Дипломатын ажил эмч юм уу, мөрдөн байцаагчийн ажилтай тун төсөөтэй. Эмч хүний үндсэн үүрэг өвчний оношийг зөв тогтоож, зөв эмчлэхэд оршино. Өвчтөнд хагалгаа хийх эсэх нь оношноосоо л хамаарах хэрэг. Дипломатууд шийдвэр гаргагчдын үйл ажиллагаанд «оношлох», «эмчлэх» -ийн аль аль нь бий. Гэхдээ эмч хүн нэг хүний амь насыг аврахын төлөө бүхнээ зориулдаг бол дипломатууд, гадаад бодлогын шийдвэр гаргагчид улс үндэстнээ аврахын төлөө ажилладаг.

Их гүрэн өөрийн хүч чадалд (эдийн засгийн, техникийн, цэргийн гэх мэт) дулдуйддаг. Жижиг, буурай улсад хүч чадлын уламжлалт элементүүд байдаггүй тул оюуны их багтаамжтай дүн шинжилгээнд дулдуйдахаас өөр зам үгүй, «Алив үйл явдлыг задлан шинжлэх, дэлхий ертөнцийг нэгдмэл цөм гэж үзэж, цаг хугацаа, орон зай, санаа бодлыг нарийн дэнсэлж, мэдлэгийг нэг мөр болгон нэгтгэн төвлөрүүлэх чадвар бол улс төрийн зүтгэлтний хамгийн эрхэм чанар мөн»⁷ гэж олон улсын харилцааны нэг нэрт судлаач бичжээ.

Шийдвэр гаргах үйл явц

Шийдвэр гаргагчид мэдээг хүлээн авч, дүн шинжилгээ хийсний дараа шийдвэр гаргах шатандаа ордог. Шийдвэр гаргах төгсгөлийн үйл явц бас л олон хэлбэрээр хэрэгждэг. Хуучин ЗХУ-д гадаад бодлогын чухал шийдвэрийг Улс төрийн товчоо, зарим тохиолдолд ерөнхий нарийн бичгийн дарга (тухайлбал, Афганистанд цэрэг оруулах тухай) дангаараа шийдэж байлаа. АНУ-д шийдвэр гаргагч гол хүн ерөнхийлөгч байдаг. Гэвч тэр дангаараа шийдэх нь ховор. Дэлхийн II дайны дараа цөөн тооны шилмэл мэргэжилтний тусламжаар асуудал шийдвэрлэх практик АНУ-д өргөн нэвтэрчээ⁸.

Мэдээжээр тодорхой асуудлаар шийдвэр гаргаж буй хүн юуны өмнө мэдээлэлд тулгуурлана. Мэдээллийн үнэн зөв, эерэг сөрөг талыг дэнсэлсний эцэст шийдвэрийн тодорхой төсөл, санал гарч ирнэ. Гэвч эцсийн шийдвэр гаргахад хэд хэдэн хүчин зүйлийг анхаарах ёстой. Улс орнууд шийдвэр гаргахдаа юуны өмнө үндэсний эрх ашгаа гол баримжаа болгодог. «Америкийн гадаад бодлого ганц одыг шүтнэ. Тэр бол Америкийн үндэсний эрх ашиг мөн» гэж Ханс Моргентау хэлсэн нь буй. Энэ нь тухайн шийдвэр үндэсний эрх ашигт хэрхэн нөлөөлөхийг урьтал болгон харна гэсэн үг.

Шийдвэр гаргагчид цаашилбал ашиг хонжоо, алдаа хохирлын харьцааг сайтар бодолцох ёстой. Энэ нь тухайн шийдвэрийг гаргаснаараа юу, хожиж, юу алдах вэ гэдгийг тунгааж бодохын нэр юм. 1979 онд ЗХУ Афганистанд цэргээ оруулсан нь гадаад бодлогод алдах, онохын харьцааг зөв тогтоох нь хичнээн чухал болохын сонгодог

жишээ юм. Цэрэг оруулснаараа. ЗХУ тухайн үедээ цэрэг-стратегийн түр зуурын амжилт олсон хэдий ч уг үйлдэл ЗХУ-ын нэр хүндийг олон улсын тавцанд унагаж, Зөвлөлтийн эсрэг үзлийг улам бэхжүүлсэн юм. Афганистанд Зөвлөлтийн олон арван мянган цэрэг эр амь эрсдэж, уг дайн Зөвлөлтийн эдийн засагт том цохилт болжээ.

Шийдвэр гаргахад анхаарах дараагийн чухал асуудал шийдвэр гаргагчдын сэтгэлзүйн онцлогтой холбоотой. Шийдвэр гаргаж байгаа хүн цаад улсынхаа хүсэл эрмэлзэл, санаа бодлыг бүрэн гүйцэд ухааран ойлгоно гэж бараг байдаггүй. Учир нь шийдвэр гаргагчид бодит байдлыг гол төлөв өөрийнхөөрөө төсөөлөхийг оролддог. Бодит байдал (цаад улсын санаа, зорилго гэх мэт), уг бодит байдлын тухай шийдвэр гаргагчдын төсөөлөл хоёр хоорондоо зөрж байдагт хэргийн учир байгаа юм. 1936 оны 3-р сард Францын арми хүний тоогоор ч, зэвсгийн тоогоор ч Германаас давуу байсан. Гитлер энэ бодит байдлыг мэдэж байсан хэрнээ Рейнландын цэрэггүй бүсэд цэргээ оруулжээ. Тэгэхдээ францууд сөрөг арга хэмжээ авбал ухрах үүрэг цэргүүддээ өгсөн байна. Гэтэл францууд бодит байдал Германы талд илүү ашигтай байна гэж төсөөлж Гитлерийн цэргийн эсрэг ямар ч сөрөг арга хэмжээ аваагүй гэдэг⁹. Энэ жишээнээс үзэхэд Францын талаарх Гитлерийн төсөөлөл зөв, харин Германы талаарх францчуудын төсөөлөл үндсэндээ буруу байсан нь талуудын үйл ажиллагаанд нөлөөлжээ.

Гадаад бодлогын шийдвэр гаргахад дээр тэмдэглэсэнчлэн тухайн үндэстний онцлог ч нөлөөлдөг. Жишээ нь, төлөвлөх, зохион байгуулах авьяасаар немцүүд италичуудаас хавьгүй давуу байхад, италичууд энэтхэгчүүдээс давуу. Америкчууд ертөнцийг сайн юм уу муу, буруу юм уу зөв, цагаан юм уу хар өнгөөр төсөөлдөг бол угаас прагматик англи хүн хар цагааны хооронд дундаж саарал өнгө бийг үргэлж бодож, тохиролцоонд хүрэхийг эрмэлздэг ажээ. Францчууд аливаа шийдвэрийн үр дагаврыг урьдчилан харж, шинжилж байж шийдвэрээ гаргадаг байхад испани хүнд нэр төрөөс эрхэм зүйл гэж үгүй.

Олон нийтийн санаа бодол нь цаг үеийн хөгжлийн хэрэгцээ шаардлагын тусгал болж байдаг. Тэгэхээр өөрийн орны олон нийтийн санаа бодлыг бодолцохгүйгээр гадаад бодлогыг амжилттай явуулах нь ховор. Гадаад тал руугаа чиглэсэн дипломатын зэрэгцээ мөн «дотоод талын дипломат»-ын бодлого зайлшгүй хэрэгтэй. Гэвч олон нийтийн санаа хэтэрхий өргөн ойлголт тул түүнд ялгавартай хандах нь зүйтэй. Аль ч улсын олон нийт ерөнхийдөө гадаад бодлогоос дотоод бодлогоо сонирхох нь илүү. Энэ ч мэдээж. Өргөн олон нийт өнөө маргаашийн тусламжаар асуудал хэрэгцээ шаардлага, талх гурил, будаагаа, жишээ нь, Монгол-Францын харилцаанаас илүү сонирхох нь хэнд ч ойлгомжтой. Барааны үнийн өсөлт, мөнгөний ханш бууралт хүмүүсийн өдөр тутмын амьдралыг шууд хөндөж байдгаас тэр юм.

Гадаад бодлогын тухайд манай нөхцөлд гурвын зэрэг санаа бодол байгаа юм уу гэж бодогдоно. Үүнд: 1) улс төрийн санаа бодол гэдэг нь улс төрийн намуудын санаа бодол юм. (Эрх баригч болон сөрөг намуудын, Улсын Их Хурлын дотор болон гадна), 2) мэдээлэлтэй санаа бодол гэдэг нь эрдэмтэд, улс төрийн тоймчид, сэтгүүлчдийн санаа бодол юм. 3) Өргөн олон нийтийн санаа бодол.

Энэ гурван санаа бодлын эхний хоёр нь гадаад бодлогын шийдвэр гаргагчдад шууд хамаатай. Өрнөдийн орнуудад олон нийтийн санаа бодол гадаад бодлоготой хэрхэн уялдаж байдаг талаар харилцан адилгүй, заримдаа бие биенийгээ үгүйсгэсэн байр суурь байдаг. Жишээ нь, зарим эрдэмтэн дипломат бодлоготон олон нийтийн санаа бодлыг дагах ёстой гэж үзэж байхад зарим нь дагуулах ёстой гэж

үзэх жишээтэй.¹⁰ Юутай ч атугай олон нийтийн санаа бодол гадаад бодлогын шийдвэр гаргах үйл явцад нөлөөлөгч чухал хүчин зүйл гэдгийг тэмдэглэх учиртай.

Гадаад бодлогын шийдвэр гаргах үйл явц зохион байгуулалтын, оюуны гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ. Зохион байгуулалтын хэсэгт тухайн улсын үндсэн хуулиар хуульчилсан төрийн тогтолцоо багтана. Гадаад бодлогын аливаа шийдвэр танин мэдэхүүд тулгуурлана. Танин мэдэхүйн үйл явц нь мэдээлэлд, мэдээлэл нь дүн шинжилгээнд тулгуурлах бөгөөд дүн шинжилгээнээс шийдвэрт хүрдэг. Монголын төр, засгийн удирдагчид, дипломатууд шийдвэр гаргах урлагийг хэдийчинээ сайн эзэмшинэ, Монгол улсын сэргэн мандалтад төдий чинээ хэрэгтэй.

1. Гадаад бодлогын шийдвэр гаргах үйл явцыг шинжлэх ухааны бие даасан салбарын хувьд Америкийн эрдэмтэн Р. Снайдер анх 1950-аад оны үед үндэслэжээ. See Richard C. Snyder and others. Foreign policy decision making. New York, The free press, 1962.
2. John L. Sherburne. The role of Outer Mongolia in Sino-Soviet relations and its significance to the USA. USAF. Alabama, 1964, pp. 47, 48.
3. Johan Galtung. A Structural theory of imperialism in the war system. ed. Richard A. Falk and Samuel Kim. West view press (Boulder, Colorado, 1980, pp. 402-447)
4. Hans J. Morgenthau. The future of diplomacy in international politics. ed. , by Robert J. Art and Robert Jervis, pp. 101 — 1 03.
5. Interrelations: Public and foreign policies, ed. R. Terschek and others. pp. 75—78.
6. Reinolds P. A. An introduction to international relations. Schenkman Publishing Company. Inc. Cambridge, Massachusetts, 1971, p. 168.
7. The war system. p. 328.
8. 1950 онд Солонгост цэрэг илгээх шийдвэрийг 14 хүний, 1962 оны карибын хямралын тухай шийдвэрийг 16 хүний бүрэлдэхүүнтэй хэсэг тус тус гаргажээ. See Glenn D. Paige. Comparative case, Analysis of crises decisions: Korea and Cuba in the war system. pp. 514-517.
9. Hans Morgenthau. The future of diplomacy in international politics. p. 107.
10. Reinolds P. A. An Introduction to international relations. p. 176.

ЯПОНЫ ГАДААД БОДЛОГО: ӨЧИГДӨР, ӨНӨӨДӨР

Ц. Батбаяр*

XX зуун төгсгөлдөө дөхөж XXI зуун наашлахын сацуу ерөнхийлөгч Ж. Бушийн 1990 онд анх санааг нь дэвшүүлсэн «дэлхийн шинэ дэг журам» ямар тогтолцоотой байх вэ, үүнд Япон ямар байр эзлэх вэ гэсэн асуулт Азийн олон орны нийслэлд тавигдах боллоо. Япон нь XXI зуун чиглэсэн шинэ нээлттэй бодлого явуулах ёстой гэсэн санал ч гарч байна. Анх 200 гаруй жил түгжигдмэл байсан Японы үүд хаалгыг 1854 онд Америкийн адмирал Перри цэргийн хүчээр нээсэн билээ.

*Дорнодахин, олон улс судлалын хүрээлэнгийн захирал, дэд эрдэмтэн.